

## **Багануур дүүргийн Эрүүл мэндийн нэгдэл**

Багануур дүүргийн Эрүүл мэндийн нэгдэл нь Төв аймгийн Эрүүлийг хамгаалах газрын даргын 1978 оны 07 дугаар сарын 16-ний өдрийн тушаалаар их эмч, сувилагч, жолооч гэсэн 3 орон тоотой түргэн тусламжийн 1 автомашин тайгаар их эмчийн салбар болон байгуулагджээ.

1980 оны 04 дүгээр сарын 17-онд Сайд нарын зөвлөлийн 49-р тушаалаар 25 ортой Нийслэлийн Багануур дүүргийн Эрүүл мэндийн нэгдсэн эмнэлэг болгон өргөтгөж Хүүхэд, дотор, төрх, эмэгтэйчүүд, мэс заслын тасгууд нээгдэн ажилласан

1988 оны 11 дүгээр сарын 02-онд эмнэлгийн иж бүрэн байгууламжийг хүлэн авснаар өдөрт 240 хүнд үйлчлэх Поликлиник, 150 ортой Стационарийн хэсэг ашиглалтанд орсон юм.

1998 оноос Нийслэлийн Багануур дүүргийн Эрүүл мэндийн нэгдэл болгон өргөжиж одоогоор 135 ортой, хэвтэн эмчлэх 6 тасаг, нарийн мэргэжлийн тусламж үзүүлэх Поликлиникийн кабинет 21 кабинет Пара клиник, Яаралтай тусламж хүлээн авах, Уламжлалт нөхөн сэргээх эмчилгээ, Клиникийн эм зүйн тасаг угаалга, ариутгал, автограж, харуул хамгаалалт зэрэг инженер техникийн албатайгаар дүүргийн нийт 26 мянга орчим хүн амд болон хил залгаа Төв, Хэнтийн аймгуудын сумдын хүн амд эрүүл мэндийн хоёрдогч шатлалын тусламж үйлчилгээг үзүүлж байна.

Түүхэн хөгжлийн явцад үе үеийн удирдлагаар 1978 оноос Д.Нина, Лхам нар, 1981 оноос Д.Цэвэгмид, Д.Шагдарсүрэн нар, 1987 оноос С.Шарав, 1991 оноос Ж.Сэд, 1993 оноос П.Янсан, 1998 оноос Л.Лувсаншарав, Я.Батбаяр, 2002 оноос Б.Сонинхүү, 2007 оноос А.Очирсүрэн нар ажиллаж иржээ.

Сүүлийн 10 жилд Бүтэц зохион байгуулалтын хувьд Эрүүл мэндийн нэгдлийн зохион байгуулалтад шилжин Нийслэлийн Эрүүл мэндийн газрын харьяанд үйл ажиллагаа явуулж эрүүл мэндийн 2 одогч шатлалын тусламж үйлчилгээг үзүүлж ирсэн.

Одоогоор 253 ажилтантай, үүнээс их эмч 52, эм зүйч 3 эмнэлгийн дунд мэргэжилтэн 110, бусад дээд мэргэжилтэн 6, бусад ажилчид 82 ажиллаж байна. Тус эрүүл мэндийн нэгдэлд клиникийн профессор 6, магистр зэрэгтэй эмч 3 нит эмч мэргэжилтнүүдийн 51% буюу 31.4 хувь нь мэргэжлийн эмч мэргэжилтнүүд ажиллаж байна.

Сувилахуйн тусламж үйлчилгээг иргэдэд чанартай, хүртээмжтэй хүргэх, төслийг дүүргийн ЗДТГ-ын дэмжлэгтэйгээр 2008 оны 6 сараас эхлэн нэг жилийн хугацаатай хэрэгжүүлсэн Эрүүл мэндийн нэгдэлд хэрэгжүүлсэн төслүүд

"Сайн дурын зөвлөгөө шинжилгээний кабинет" төслийн зорилго нь хүмүүсийн амьдралын хэв маягт зан үйлийг өөрчлөх замаар БЗДХ-н халдвараас сэргийлэх /ХДХВ/ сэтгэл зүйн зөвлөгөө өгөх болон дэмжлэг үзүүлэх үндсэн зорилготой. "Эрүүл мэндийн салбарын хөгжил-2" "Эрүүл мэндийн төлөө хамтдаа 2008 онд Эрүүл мэндийн нэгдэл өрхийн эмнэлгүүдийн хоорондын уялдаа холбоо, өрхийн эмнэлгийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор хэрэгжиж эхэлсэн.